



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ
СОНГУУЛИЙН ТОЙРОГТ УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН СОНГУУЛЬ ЗОХИОН
БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛД АУДИТ ХИЙЖ ДҮГНЭЛТ ГАРГАХ

АУДИТЫН КОД: ГНАГ-2024/15-ШТА-НА-БНА

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Утас: 70442584 цахим хуудас: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер М.Алтантуяа

Утас: 70442424 цахим хуудас: altantuyam@audit.gov.mn

Аудитор Д.Даваадорж

Утас: 88953144 цахим хуудас: Davaadorjd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг

Баянхонгор хот 2024 он дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn



АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН ТОЙРОГТ УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛД АУДИТ ХИЙЖ ДҮГНЭЛТ ГАРГАХ

Агуулга

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх?	3
Баянхонгор аймагт Аймаг, сумын ИТХ-ын сонгуулийг зохион байгуулахад улсын төсвөөс олгох зардлыг урьдчилан тооцоолохдоо шаардлагатай мэдээллийг гаргуулан авч СЕХ төсвийг тооцож удирдамж гарган хуваарилсан бөгөөд аймгийн сонгуулийн хороо нь удирдамжийн дагуу сонгуулийн хорооддоо хуваарилсан байна.	5
1.1.1 Аймгийн сонгуулийн хорооны сонгууль зохион байгуулахад улсын төсвөөс олгох хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг бодитой тооцсон байна.	5
1.1.2 Сонгуулийн хороо болон хэсгийн хороодод улсын төсвөөс сонгууль зохион байгуулах зардлыг хуваарилахдаа СЕХ-ноос ирүүлсэн төсвийн зарцуулалтын удирдамжийг мөрдөж ажилласан байна.	5
1.1.3 Аймгийн Цагдаагийн газар, Улсын бүртгэлийн хэлтэс Аймаг, сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой төсвийн зарцуулалтын удирдамжийг мөрдөж ажилласан байна..	8
Сонгуулийн хороо нь хуваарилагдсан төсвийн хүрээнд төсвийг зарцуулсан байна.	9
1.2.1. Сумдын сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал болон хоолны зардлаас нийгмийн даатгалын шимтгэлийн хувийг буруу тооцоолсон байна.	9
1.2.3. Аймгийн Сонгуулийн хорооноос сумдын сонгуулийн хорооны зардлын зарцуулалтад хяналт тавьж ажилласан байна.	11
ДҮГНЭЛТ:	12



Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын их хурал
ЗГ	Засгийн газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
АСХ	Аймгийн сонгуулийн хороо
МТ	Мэдээлэл технологи
МТБ	Мэдээлэл технологийн баг
УБЕГ	Улсын бүртгэлийн Ерөнхий газар
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
УБХ	Улсын бүртгэлийн хэлтэс
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал



Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-д заасан бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол, МУЕА-ын 2023 оны А/162 дугаар тушаалыг тус тус үндэслэн “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тойрогт улсын төсвөөс санхүүжүүлсэн сонгууль зохион байгуулахтай холбогдсон зардлын гүйцэтгэлд аудит хийж дүгнэлт гаргах”-д аудит хийв. АНСДИТХ-ын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан аудитын тайланг аймгийн Сонгуулийн хороо, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилт

Дээрх зорилтын хүрээнд дараах чиглэлийн дагуу аудитыг гүйцэтгэв.Үүнд:

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх?
2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх;

Аудитын хамарсан хүрээ

Аудитад аймаг, сумын сонгуулийн хороод, аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газарт олгосон сонгууль зохион байгуулахтай холбогдон зардлыг хамруулан шалгав.

Аудитын хязгаарлалт

Аймгийн сонгуулийн хороо болон аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, аймаг дахь Цагдаагийн газарт сонгууль зохион байгуулахтай холбоотой батлагдсаны дагуу хуваарилагдаж ирсэн зардлаас бусад зардал хамаарахгүй.

Аудитыг АДБОУС 100, 400, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт Нийцлийн аудит MNS 6817:2020, Нийцлийн болон Санхүүгийн аудитын арга зүйг ашиглан улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын талаар холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, судалгаа, хөтөлбөр, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль;
- Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль;
- Сонгуулийн төв байгууллагын тухай хууль;
- Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны А/17 дугаар тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”
- Бусад холбогдох хууль, дүрэм, журам.



Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, бөгөөд тэргүүлэх аудитор Б.Мөнхбат удирдаж, аудитын менежер М.Алтантуяа чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитор Д.Даваадорж гүйцэтгэв.

Аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр эхлүүлж, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга Тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажуулж, 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр аймгийн Сонгуулийн хороонд хүргүүлэв.



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БҮЛЭГ 1.1 Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгийг хууль, журмын дагуу төлөвлөж хуваарилсан эсэх

Баянхонгор аймагт Аймаг, сумын ИТХ-ын сонгуулийг зохион байгуулахад улсын төсвөөс олгох зардлыг урьдчилан тооцоолохдоо шаардлагатай мэдээллийг гаргуулан авч СЕХ төсвийг тооцож удирдамж гарган хуваарилсан бөгөөд аймгийн сонгуулийн хороо нь удирдамжийн дагуу сонгуулийн хорооддоо хуваарилсан байна.

1.1.1 Аймгийн сонгуулийн хорооны сонгууль зохион байгуулахад улсын төсвөөс олгох хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг бодитой тооцсон байна.

Баянхонгор аймагт 2024 оны Аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийг зохион байгуулах улсын төсвөөс гарах зардлын хэрэгцээ шаардлагыг тодорхойлохдоо сонгогчийн тоо, сонгууль зохион байгуулахад оролцох ажилтны тоо, сум болон хэсгийн хорооны тоо тэдгээрийн байршил хоорондох зай зэрэг шаардлагатай мэдээллийг Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлсний үндсэн дээр сонгууль зохион байгуулах зардлын төсөв хуваарилагдсан байна.

Төсвийн хэрэгцээ шаардлагыг дээрх байдлаар тодорхойлж байгаа нь хэсгийн хорооны гишүүдийн урамшуулал, хоол, унааны зардал, мэдээ дамжуулах зардлыг тооцоолох гол үзүүлэлт болсон байна.

Бичиг хэрэг, сургалт сурталчилгаа, шуудан холбоо, санал өгөх байрны эрчим хүч, халаалт, санал авах байр бэлтгэх зэргийн зардлыг тогтмол байхаар тооцож ирүүлсэн байна.

1.1.2 Сонгуулийн хороо болон хэсгийн хороодод улсын төсвөөс сонгууль зохион байгуулах зардлыг хуваарилахдаа СЕХ-ноос ирүүлсэн төсвийн зарцуулалтын удирдамжийг мөрдөж ажилласан байна.

Сонгуулийн ерөнхий хорооноос аймгийн сонгуулийн хороонд 6 удаагийн удирдамжийн дагуу 21 төрлийн нийт 1,355,823.4 мянган төгрөгийн санхүүжилтийг хуваарилсан байна.

Энэ удаагийн сонгуулийн зардалд Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 16 дугаар тогтоолоор батлагдсан “Саналын хуудсыг хэвлүүлэх, хүргүүлэх, хадгалах, хамгаалах” журмын 5.1, 5.4-д заасныг үндэслэн 2021 оны Монгол улсын ерөнхийлөгчийн сонгуулийн хадгалах хугацаа дууссан саналын хуудас устгах зардлыг төсөвлөж өгсөн байна.

Санхүүжилтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 1. Сонгуулийн ерөнхий хорооноос хуваарилсан зардал /мянган төгрөг/

№	Зардлын нэр	СЕХ-ны 2024.08.19-ний өдрийн 3/777	СЕХ-ны 2024.09.05-ний өдрийн 3/834	СЕХ-ны 2024.09.13-ний өдрийн 3/852	СЕХ-ны 2024.09.20-ний өдрийн 3/893	СЕХ-ны 2020.09.27-ний өдрийн 3/909	СЕХ-ны 2020.10.05-ний өдрийн 3/940	Нийт
1	Маягт хэвлэмэл хуудас хэвлүүлэх	1,427.5						1,427.5
2	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	16,811.0						16,811.0
3	МТБ, даамлын сургалт	25,616.0						25,616.0



АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХҮРЛЫН ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН ТОЙРОГТ УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛД АУДИТ ХИЙЖ ДҮГНЭЛТ ГАРГАХ

4	Бичиг хэрэг	16,720.0								16,720.0
5	Шуудан холбоо	20,400.0								20,400.0
6	Унаа	86,450.0								86,450.0
7	Санал авах байр бэлтгэх	29,680.0								29,680.0
8	Сурталчилгаа				20,000.0					20,000.0
9	МТБ-ийн гишүүний холбоо, унааны зардал				1,820.0					1,820.0
10	Саналын хуудас, төхөөрөмжийн авах, хүргэх зардал				53,168.0					53,168.0
11	Томилолтын зардал				17,268.0					17,268.0
12	Сүлжээний судалгаа хийх зардал					2,399.0				2,399.0
13	Саналын хуудас устгал зардал					2,111.5				2,111.5
14	Эрчим хүчний эх үүсвэр ашиглах зардал					10,640.0				10,640.0
15	Санал авах байрны түлшний зардал						11,400.0			11,400.0
16	Сурталчилгааны материал тараах унааны зардал						14,840.0			14,840.0
17	Шуурхай багийн зардал						4,660.0			4,660.0
18	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, хоолны зардал							890,052.8		890,052.8
19	МТБ, даамлын урамшуулал, хоолны зардал							113,825.6		113,825.6
20	Тоног төхөөрөмж тохиргоо хийх зардал							7,630.0		7,630.0
21	Болзошгүй зардал							8,904.0		8,904.0
НИЙТ ДҮН		43,854.5	153,250.0	92,256.0	15,150.5	30,900.0	1,020,412.4	1,355,823.4		

Эх сурвалж: СЕХ-ны албан тоотууд

Дээрх зардлаас сумдын сонгуулийн болон хэсгийн хороодод нийт 1,180,992.2 мянган төгрөгийн зардлыг хуваарилж сумдын сонгуулийн хорооны дансанд 4 удаагийн гүйлгээгээр 1,180,992.2 мянган төгрөгийн шилжүүлэг хийсэн байна.

Хүснэгт № 2. Сумдын сонгуулийн хороонд хуваарилсан зардал /мянган төгрөг/

№	Зардлын төрөл	Нийт зардал	Үүнээс:		Тайлбар
			Сумдад хуваарилсан	АСХ зохион байгуулсан	
1	Маягт хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	1,427.5		1427.5	Сонгуулийн хорооны маягт хэвлэх зардлыг аймаг бүрд 300,000₮ төгрөгөөр хуваарилсан. Нэр дэвшигчийн үнэмлэх хэвлэх зардлыг нийт мандатын тоогоор (1 мандат * 5 хүн * 500₮) тооцсон байна.
2	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	16,811.0	9195.0	7,616.0	Аймгийн сонгуулийн хорооны дарга, нарийн бичиг, нягтлан бодогч нарын УБ хотод хийх томилолтыг 3 өдрөөр, хоолны зардлыг 2 өдрөөр ((3өдөр*150,000+2өдөр*50,000₮)*3хүн), замын зардлыг (1км*700₮* 2тал) тус тус тооцож 2,400,000₮ хуваарилсан байна. Сумдад томилолт (3 хүн*1 өдөр*130,000₮)*19сум 7,410,000₮, унааны зардал сум руу ирж очих дундаж тарифаар 1,785,000₮, хоолны зардал нэгдсэн журмаар хоолонд оруулахаар зохицуулж аймгийн 2,273,700₮, сургалтын зардлыг 2,942,300₮-ийг тус тус сонгуулийн хороонд хуваарилсан байна.



**АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХҮРЛЫН ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН ТОЙРОГТ УЛСЫН
ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХӨЛБӨГДСӨН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛД АУДИТ
ХИЙЖ ДҮГНЭЛТ ГАРГАХ**

3	МТБ сургалт	даамлын	25,616,0		25,616.0	МТБ-ийн 2 гишүүний УБ хотод хийх сургалтын замын зардал (1км*700ф*2тал), томилолт (1өдөр*200,000ф*2хүн) 1,310,000ф, сумдын даамлын томилолт, унааны зардал 14,556,000ф, хоолны зардлыг нэгдсэн журмаар хоолонд оруулахаар зохицуулж 9,750.000ф-ийг тус тус аймгийн сонгуулийн хороонд хуваарилсан байна.
4	Бичиг зардал	хэргийн	16,720.0	15,720.0	1,000.0	Аймгийн сонгуулийн хороонд 1 сая төгрөг, Сум бүрд 150,000ф, хэсэг тус бүрд 120,000ф
5	Шуудан холбооны зардал		20,400.0	18,900.00	1,500.0	Аймгийн сонгуулийн хороонд 1,5 сая төгрөг, Сум, хэсэг тус бүрд 150,000ф
6	Унааны зардал		86,450.0	67,900.0	18,550.0	Унааны зардлыг аймгийн сонгуулийн хороонд (3500км*700ф), Сумдад 1 сумд 700км 700ф-өөр нэг хэсгийн унааны зардлыг 600км-ийг 700ф-өөр тооцсон байна.
7	Сурталчилгаа		20,000.0	9,000.0	11,000.0	Аймгийн сонгуулийн хороонд 11,000,000ф, сум тус бүрд 450,000ф-өөр хуваарилсан байна
8	Санал авах байр бэлтгэх зардал		29,680.0	29,680.00		Санал авах байр бүрд 280,000ф хуваарилсан байна.
9	Саналын хуудас, төхөөрөмжийн авах хүргэх ачаа, томилолтын зардал		53,168.0		53,168.0	Аймгийн сонгуулийн хороонд саналын хуудас, санал тоолох төхөөрөмж, дагалдах хэрэгслийг СЕХ-оос авах, хүргэж өгөх, сумд хэсгийн хороонд хүргэж өгөх зардалд 53,168,000ф хуваарилсан байна. Сумдын хэсгийн хороонд томилолтын зардал 9,690,000ф (19сум3хүн*1өдөр*170,000ф) унааны зардлыг 5,600,000ф(20сум*400км*700ф) тус тус тооцсон байна.
10	МТБ-ийн гишүүний холбоо, унааны зардал		1,820.0		1,820.0	Аймгийн сонгуулийн хороонд 1,820,000ф -ийг хуваарилсан байна.
11	Томилолтын зардал		17,268.0	9,730.0	7,538.0	Аймгийн Сонгуулийн хорооны томилолт, унааны зардалд 7,538,000ф (3хүн *2 удаа *200,000ф+1280 км *700ф), сумдын сонгуулийн хороонд 9,730,000ф (2 хүн*170,000ф)+ унааны зардал тухайн сумын тарифаар.
12	Сүлжээний судалгаа зардал	хийх	2,399.0		2,399.0	УБЕГ-аас газар дээр нь очиж сүлжээний судалгааг хийх зайлшгүй газруудын зай, хэсгийн тоог гаргаж хүргүүлснийг үндэслэн зардлыг хуваарилсан байна. (Очих газар хүртэлх зай*700ф)+томилолт гэж тооцсон байна.
13	Саналын хуудас устгах зардал		2,111.5		2,111.5	Аймгийн сонгуулийн хорооноос ирүүлсэн хүргүүлсэн саналыг үндэслэн 2021 оны МУЕ-ийн сонгуулийн саналын хуудас устгах зардлыг хуваарилсан байна.
14	Эрчим хүчний эх үүсвэр ашиглах зардал		10,640.0	10,640.0		Эрчим хүчний эх үүсвэр дутагдалтай хэсгийн хороодод ашиглах зориулалтаар хэсгийн хороо бүрд 140,000ф-өөр тооцож хуваарилсан байна.
15	Санал байрны зардал	авах түлшний	11,400.0	11,400.0		Аймгийн төв, сумын төвийн хэсгийн хорооноос бусад хөдөө баг дээр байрлах 76 хэсгийн хороонд тус бүрд нь 150,000ф хуваарилсан байна.
16	Сурталчилгааны материал тараах зардал		14,840.0	14,840.0		Сурталчилгааны материалыг хэсгийн хороо болон сонгогчдод тараах зориулалтаар (106 хэсэг*200км*700ф) -өөр тооцож хуваарилсан байна.
17	Шуурхай зардал	багийн	4,660.00		4,660.00	Аймгийн сонгуулийн хороонд хуваарилсан байна.



АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХҮРЛЫН ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН ТОЙРОГТ УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛД АУДИТ ХИЙЖ ДҮГНЭЛТ ГАРГАХ

18	Сонгуулийн хорооны гишүүний гишүүдийн урамшуулал, хоолны зардал, НДШ	890,052.8	879,334.4	10,718.4	Сумын сонгуулийн хорооны 140 гишүүн, сумдын 106 хэсгийн 924 гишүүн, аймгийн сонгуулийн хорооны 11 гишүүнд 794,690,000₮-ийн урамшуулал, 95,262,800₮-ийн НДШ-ийн зардалд нийт 890,052,800₮ хуваарилсан байна. $(11 \times 974,400₮) + (140 \times 884,800₮) + (924 \times 817,600₮) = 890,052,800₮$
19	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, НДШ	113,825.6	104,652.8	9,172.8	Сумын хэсгийн хорооны 128 даамал, аймгийн МТБ-ийн 7 гишүүний урамшууллын зардалд 101,630,000₮, НДШ-ийн зардалд 12,195,600₮ тус тус хуваарилсан байна. $(7 \times 1,170,000₮) + (128 \times 730,000₮) = 113,825,600₮$
20	Төнөг төхөөрөмжийн тохиргоо хийх зардал	7,630.0		7,630.0	Тохиргоо хийх төхөөрөмжийн тоог харгалзан томилолтын зардлыг 3 хоногоор / багийн гишүүн * 3 * 90,000₮ /, / унаа зардлыг / хэсгийн тоо * 200 км * 700₮ / тооцож хуваарилсан байна.
21	Болзошгүй зардал	8,904.00		8,904.00	Аймгийн сонгуулийн хороонд хуваарилсан байна.
	Нийт	1,355,823.4	1,180,992.2	174,831.2	

Эх сурвалж: Аймгийн сонгуулийн хорооны төсвийн хуваарь

Сумдын сонгуулийн хороодод унааны зардлаас бусад зардлыг СЕХ-ноос ирүүлсэн удирдамжийн дагуу хуваарилсан байна.

Унааны зардлыг сумдад хуваарилахдаа УИХ-ын сонгууль зохион байгуулахад гарсан унааны зардлын гүйцэтгэлтэй уялдуулан төсөв хуваарилж өгсөн нь төсвийг үр ашигтай бодитой зарцуулахад чиглэсэн байна.

1.1.3 Аймгийн Цагдаагийн газар, Улсын бүртгэлийн хэлтэс Аймаг, сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой төсвийн зарцуулалтын удирдамжийг мөрдөж ажилласан байна..

Аймаг, Нийслэл, Сум, Дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т заасны дагуу Улсын бүртгэлийн Ерөнхий газраас ИТХ-ын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдуулан аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст 97,057.7 мянган төгрөгийн төсөв хуваарилагдаж ирсэн боловч зарим зардлын төсвийн хуваарилалтыг бодитой тооцоогүй байна.

Аймаг, Нийслэл, Сум, Дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т заасны дагуу Аймгийн Цагдаагийн газарт ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн хамгаалалтын зардалд 40,518.0 мянган төгрөгийг тус тус хуваарилсан байна

Хүснэгт № 3. Зарим төрийн захиргааны байгууллагуудад хуваарилсан төсөв /мянган төгрөг/

	Зардлын төрөл	Хоолны зардал, цалин, шуурхай баг	Шуудан холбооны зардал	Дотоод албан томилолт	Бичиг хэрэг	Бараа үйлчилгээний бусад зардал	Хичээл практик	Тээвэр шатахуун	Бичиг хэрэг	Нийт дүн
1	Аймгийн Цагдаагийн газар	64,155.0		19,334.0	4,309.7	5,400.0	2,109.0	1,750.0		97,057.7
2	Аймгийн УБХ	26,568.0	10,950.0					3,000.0		40,518.0
	Нийт дүн	90,723.0	10,950.0	19,334.0	4,309.7	5,400.0	2,109.0	4,750.0	24,456.0	137,575.7

Эх сурвалж: УБЕГ, ЦЕГ-аас ирүүлсэн тайлангаар.



Дээрх төсвийг дээд газраас ирүүлсэн хуваарийн дагуу аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэст зарцуулалтын эрхийн хүсэлтийг хүргүүлэн зарцуулах эрхийг нээлгэсэн байна.

БҮЛЭГ 1.2 Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх?

Сонгуулийн хороо нь хуваарилагдсан төсвийн хүрээнд төсвийг зарцуулсан байна.

1.2.1. Сумдын сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал болон хоолны зардлаас нийгмийн даатгалын шимтгэлийн хувийг буруу тооцоолсон байна.

Сонгуулийн Ерөнхий хорооноос Баянхонгор аймгийн сонгуулийн хороонд 1,355,823.4 мянган төгрөг хуваарилсныг гүйцэтгэлээр 1,348,083.4 мянган төгрөгийг зарцуулж 7,740.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Сумдын сонгуулийн хороо сонгуульд ажилласан иргэдийн цалин, урамшууллаас НДШ тооцохдоо даатгуулагчийн кодыг буруу сонгож 3,471.8 мянган төгрөгийн шимтгэлийн зөрүү үүссэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Баацагаан, Баян-Овоо, Баян-Өндөр, Баянбулаг, Баянговь, Баянхонгор, Богд, Галуут, Бөмбөгөр, Гурванбулаг, Жаргалант, Хүрээмарал, Өлзийт, Шинэжинст сумын сонгуулийн хороод 3,126,720 төгрөгийн шимтгэл илүү шилжүүлж НДШ-ийн авлага үүссэн байна.
- Заг сумын сонгуулийн хороо НДШ-ийн тайлангаа илгээгүй илүү дутуу төлөлт байгаа эсэх нь тодорхойгүй байна.
- Эрдэнэцогт, Жинст сумын сонгуулийн ерөнхий хороод нь 345,122 төгрөгийн НДШ-ийг дутуу шилжүүлж өр үүссэн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 21.1 "Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө", Төсвийн тухай хуулийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд дээрх үүссэн 3,126,720 төгрөгийн илүү төлөлтийг Нийгмийн даатгалын хэлтсээс буцаалт хийлгэн Орон нутгийн төсвийн орлогын дансанд төвлөрүүлэх төлбөрийн актыг тогтоох, нийгмийн даатгалын тайлан илгээгээгүй байгаа 1 сумын сонгуулийн хороо болон өр үүссэн 2 сумын сонгуулийн хороод нийгмийн даатгалтай тооцоо нийлж өр авлагыг барагдуулах албан шаардлыг аймгийн сонгуулийн хороонд хүргүүлэв.

Аймаг, сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн хамгаалалтын зардалд 40,518.0 мянган төгрөг аймгийн Цагдаагийн газарт хуваарилагдаж гүйцэтгэлээр 40,518.0 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Аймаг, сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдуулан аймгийн Улсын хэлтэст 97,057.7 мянган төгрөг батлагдаж ирсэн бөгөөд 97,057.7 мянган төгрөгийг зарцуулсан байна. Цалин, бичиг хэргийн зардлыг УБЕГ-аас төсөв хуваарилалт хийхдээ Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсээс ирүүлсэн санал, судалгааны дагуу хуваарилалт хийж өгсөн боловч аймгийн хэсгийн хорооны тоонд өөрчлөлт орсонтой холбогдон цалин, бичиг хэргийн зардлыг хэтрүүлэн албан томилолт болон тээвэрлэлтийн зардлыг хэмнэж гүйлгэж зарцуулсан байна.



УБЕГ-ын 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 22/13465 дугаартай албан бичгээр тухайн нэгж бодит гүйцэтгэлээр зардлыг хэмнэсэн бол бусад хүрэлцэхгүй, мөн гэнэтийн гарсан зардалд зарцуулж болохыг мэдэгдсэн чиглэлийн дагуу зардлыг хооронд нь гүйлгэн зарцуулсан байна.

Хүснэгт № 4. УБХ-ын төсвийн задаргаа /мянган төгрөг/

Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Тайлбар
1 Цалин	63,855.0	64,326.9	(471.9)	Итгэмжлэгдсэн ажилтын тоо төсөвт 86 хүнээр төсөвлөгдөж гүйцэтгэл нь 87 хүн ажилласан байна.
2 Шуурхай баг	300.0	300.0	-	
3 Нэрсийн жагсаалт хэвлэх	4,309.7	5,057.7	(748.0)	Хэсгийн хорооны тоо өөрчлөгдөж 1 хэсгийн хорооны СНЖ хэвлэсэнтэй холбоотой хэтэрсэн байна.
4 СНЖ хэсгийн хороонд хүргэх шатахуун	1,750.0	1,489.1	260.9	
5 Итгэмжлэгдсэн ажилтны сургалт	2,109.0	2,109.0	-	
6 Томилолт	12,508.0	13,334.0	(826.0)	Сумын бүртгэгч нарын тоног төхөөрөмж буцааж хүргэх зардал төсөвт суугаагүй.
7 Итгэмжлэгдсэн ажилтны замын зардал	5,300.0	3,265.0	2,035.0	Сум хоорондын зай, замын зардлын зөрүүгээс хэмнэгдсэн. Хэмнэгдсэн зардлыг бусад зардалд гүйлгэн зарцуулсан байна.
СНЖ хэсгийн хороонд хүргэх	390.0	640.0	(250.0)	СНЖ хүргэх, хэсгийн хороодод сүлжээ төстлэх ажил давхар явагдсантай холбоотой зардал хэтэрсэн байна.
Тоног төхөөрөмж хүргэх	1,136.0	1,136.0		
Тээвэр	5,400.0	5,400.0		
Нийт дүн	97,057.7	97,057.7	-	

Эх сурвалж: УБХ-ийн гүйцэтгэлийн тайлан

1.2.2 Сумдын сонгуулийн хороо нь зардлын гүйцэтгэлийн тайланг аймгийн сонгуулийн хороонд зөрүүгүй тайлагнасан байна.

Сумдын сонгуулийн хорооны тайланг Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 3 дугаар хавсралт маягтын дагуу тайланг гаргаж ирүүлснийг аймгийн сонгуулийн хорооны нягтлан бодогч хүлээн авч СЕХ-нд нэгдсэн тайланг хүргүүлсэн байна.

Сумдын ирүүлсэн зардлын тайланг анхан шатны баримтаас тулган шалгахад Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1¹ дэх заалтыг хэрэгжүүлж ажилласан байна.

2024 оны ээлжит сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд сонгуулийн хороодод хуваарилсан санал авах үйл ажиллагаанд ашигласан санал тэмдэглэх бүхээг, зөөврийн саналын хайрцаг, ИСР төхөөрөмжийн саналын хайрцаг зэрэг бараа

¹ "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно"



материалыг СЕХ-ны даргын А/73 дугаар захирамжийн дагуу сумын сонгуулийн хороод 44,744.3 мянган төгрөгийн хөрөнгийг өөр өөрийн сумын ЗДТГ-т шилжүүлэн нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн байна.

Сумдын сонгуулийн хороод нь тайлан ирүүлэхдээ Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны А/17 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 4.3² дахь заалтын дагуу тайлагнасан байна.

1.2.3. Аймгийн Сонгуулийн хорооноос сумдын сонгуулийн хорооны зардлын зарцуулалтад хяналт тавьж ажилласан байна.

Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 3.4 дэх заалтын дагуу СЕХ нь аймгийн сонгуулийн хорооны сонгуулийн зардлын зарцуулалтад, аймгийн сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хорооны сонгуулийн зардлын зарцуулалтад тус тус хяналт тавих чиг үүрэгтэй байгаа ба аймгийн сонгуулийн нягтлан бодогч нь сумдын сонгуулийн зардлын тайлан, анхан шатны баримтыг аймгаас хуваарилсан зардлын нэгтгэлтэй тулган хүлээн авч хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт № 5. Аймгийн сонгуулийн хорооны гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөг/

4.3.1 Сонгуулийн зардлын тайлан өгөх тухай албан бичиг
4.3.2 Тайлангийн товч танилцаалга, тодруулга
4.3.3 Сонгуулийн зардлын гүйцэтгэлийн тайлан
4.3.4 Санхүүгийн анхан шатны баримтуу /хүлээлгэн өгсөн акт/



АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХҮРЛЫН ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН ТОЙРОГТ УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛД АУДИТ ХИЙЖ ДҮГНЭЛТ ГАРГАХ

№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	1,427.5	1,427.5	-
2	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	16,811.0	16,811.0	-
3	МТБ, даамлын сургалт	25,616.0	25,616.0	-
4	Бичиг хэрэг	16,720.0	16,751.1	-
5	Шуудан холбоо	20,400.0	20,400.0	-
6	Унааны зардал	86,800.0	86,800.0	-
7	Санал авах байр бэлтгэх	29,680.0	29,680.0	-
8	Сурталчилгааны зардал	20,000.0	20,000.0	-
9	МТБ-ийн гишүүний холбоо, унааны зардал	1,820.0	1,820.0	-
10	Саналын хуудас төхөөрөмжийн авах, хүргэх зардал	53,168.0	47,952.0	5,216.0
11	Томилолтын зардал	17,268.0	17,268.0	-
12	Сүлжээний судалгаа хийх зардал	2,399.0	2,399.0	-
13	Саналын хуудас устгах зардал	2,111.5	2,111.5	-
14	Эрчим хүчний эх үүсвэр ашиглах зардал	11,620.0	11,620.0	-
15	Санал авах байрны түлшний зардал	12,450.0	12,450.0	-
16	Сурталчилгааны материал тараах унааны зардал	14,840.0	14,840.0	-
17	Шуурхай багийн зардал	4,660.0	4,660.0	-
18	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, хоолны зардал	890,052.8	890,011.0	41.8
19	МТБаг, даамлын мөнгөн урамшуулал, хоолны зардал	113,825.6	113,781.8	43.8
20	Тоног төхөөрөмжийн тохиргоо хийх	7,630.0	7,630.0	-
21	Болзошгүй зардал	2,524.0	31.1	2,492.9
22	Хоолны зардал	4,000.0	4,000.0	-
23	СӨХороонд төвлөрүүлсэн	-	7,794.6	(7,794.6)
НИЙТ ДҮН		1,355,823.4	1,355,854.5	-

Аудитаар нийт 3,471,842 төгрөгийн зөрчил илэрч 3,126,720 төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, алдаа зөрчлийг арилгах 345,122 төгрөгийн 1 албан шаардлага өглөө.

_____оОо_____

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Сонгуулийн ерөнхий хороо нь Баянхонгор аймагт Аймаг, сумын ИТХ-ын сонгуулийг зохион байгуулах улсын төсвөөс олгох зардлыг шаардлагатай мэдээллийг үндэслэн төлөвлөж, 1,355,823.4 мянган төгрөг хуваарилсан байна.

2. Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны А/17 дугаар тогтоолоор баталсан "Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам"-ыг мөрдөж ажилласан байна.

_____оОо_____



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 11 сарын 22 өдөр

Дугаар 148/АО 571255

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол, МУЕА-ын 2023 оны А/162 дугаар тушаалыг үндэслэн Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас “Аймаг, Нийслэл, Сум, Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тойрогт улсын төсвөөс санхүүжүүлсэн сонгууль зохион байгуулахтай холбогдсон зардлын гүйцэтгэлд аудит хийж дүгнэлт гаргах”-д хийсэн нийцлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баацагаан, Баян-Овоо, Баян-Өндөр, Баянбулаг, Баянговь, Баянхонгор, Богд, Галуут, Бөмбөгөр, Гурванбулаг, Жаргалант, Хүрээмарал, Өлзийт, Шинэжинст сумын сонгуулийн хороод нь сонгуульд ажилласан иргэдийн цалин, урамшууллаас НДШ тооцохдоо даатгуулагчийн кодыг буруу сонгож 3,126,720 төгрөгийг илүү шилжүүлсэн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 18.1 “Ажил олгогч болон энэ хуулийн 7.2, 7.3, 7.4, 7.5-д заасан даатгуулагч дараах хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө” 7.3.4 “ажил олгогч, хүнтэй хөдөлмөрийн гэрээ, ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагч” 7.6 “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5.1.1-д заасан насанд хүрсэн энэ хуулийн 7.3.4-т заасан тэтгэвэр авагч өөрөө хүсвэл энэ хуулийн 6.1.1-д заасан нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болно” 7.2.4 “Нэг ба түүнээс дээш сарын хугацаагаар хөдөлмөрийн чадвараа түр алдсан, жирэмсний болон амаржсаны амралттай байгаа энэ хуулийн 7.2.1, 7.2.2, 7.2.3-т заасан ажилтан”, Төсвийн тухай хуулийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан

005050384

шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.5 "Бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Нийгмийн даатгалын хэлтэст илүү шилжүүлсэн 3,126,720 (Гурван сая нэг зуун хорин зургаан мянга долоон зуун хорин) төгрөгийг Нийгмийн даатгалын сангаас буцаалт хийлгэн төлбөрийг Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2024 оны 12 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэхийг Баянхонгор аймгийн Сонгуулийн хорооны дарга Д.Энхжаргал, нягтлан бодогч С.Гэрэлмаа нарт даалгав^{2,3}.

ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН⁴:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

АУДИТОР

Д.ДАВААДОРЖ



¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана"

³ Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

⁴ Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 11 сарын 22 өдөр

Дугаар 364/А0571255

Номгон

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгуулийн тойрогт улсын төсвөөс санхүүжүүлсэн сонгууль зохион байгуулахтай холбогдсон зардлын гүйцэтгэлд аудит хийж дүгнэлт гаргах-д хийсэн нийцлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрдэнэцогт, Жинст сумын сонгуулийн хороод нь сонгуульд ажилласан иргэдийн цалин, урамшууллаас НДШ-ийг дутуу тооцож 345,122 төгрөгийн өр үүссэн, Заг сумын сонгуулийн хороо НДШ-ийн тайлангаа мэдээлээгүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21.1 "Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө", Төсвийн тухай хуулийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.


Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Заг, Эрдэнэцогт, Жинст сумдын сонгуулийн хороог Нийгмийн даатгалын газартай тооцоо нийлж өрийг барагдуулж нотлох баримтыг 2024 оны 12 дугаар сарын 25-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

5041092

2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн сонгуулийн хорооны дарга Д.Энхжаргал, нягтлан бодогч С.Гэрэлмаа нардаар даалгав¹.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН²:
 БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
 ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ
 АУДИТОР Д.ДАВААДОРЖ



¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно